

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**АУДИТЫН НЭР: АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИТХ-ЫН 2025 ОНЫ НӨХӨН
СОНГУУЛЬД ОРОЛЦСОН НАМ, ЭВСЭЛ, НЭР ДЭВШИГЧИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГ
ХЯНАЖ, ОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЭХ**

АУДИТЫН КОД: БНА-2025/79-ШТА-НА

**Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат**

Утас: 70442584 цахим хуудас: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер М.Алтантуяа

Утас: 70442424 цахим хуудас: altantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Должмаа

Утас: 70442424 цахим хуудас: doljmaab@audit.gov.mn

Аудитор А.Адилзаяа

Утас: 70442424 цахим хуудас: adilzayaa@audit.gov.mn

Аудитор Д.Цэдэвцэвээн

Утас: 70442424 цахим хуудас: tsedevtseveend@audit.gov.mn

Аудитор Д.Оюун-Эрдэнэ

Утас: 70442424 цахим хуудас: oyun-erdenede@audit.gov.mn

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	1
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ	2
БҮЛЭГ 1. АЙМГИЙН ИТХ-ЫН 2025 ОНЫ НӨХӨН СОНГУУЛЬД НЭР ДЭВШИГЧДЭД ИРГЭД, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭЭС МӨНГӨН ХАНДИВ ӨГӨӨГҮЙ БАЙНА.....	4
БҮЛЭГ 2. НЭР ДЭВШИГЧДИЙН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ДАНСНААС ГАРСАН ЗАРДАЛ СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ДЭЭД ХЭМЖЭЭНЭЭС ХЭТРЭЭГҮЙ БАЙНА.....	5
ДҮГНЭЛТ:	6

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УИХ	Улсын их хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МАН	Монгол Ардын нам

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т заасан үндэслэлээр Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 15 дугаар зүйлийн 15.1 дэх заалтыг үндэслэн УИХ-ын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 05 дугаар тогтоол, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/02 дугаар тушаал, “Төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулан батлах тухай” 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/09 дугаар тушаал, Монгол Улсын Ерөнхий аудиторов “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/108 дугаар тушаал, “Тушаалын хавсралтад нэмэлт оруулах тухай” 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/44 дугаар тушаалыг тус тус үндэслэн аудитыг гүйцэтгэв. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх “Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ” гэж заасныг үндэслэн нам, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянаж баталгаажуулав.
Аудитын зорилт	Аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчийн хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон нам болон нэр дэвшигчдийн төвлөрүүлсэн орлого, иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив, сонгуулийн зардлыг хянаж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв. Дээрх зорилтын хүрээнд дараах чиглэлийн дагуу аудитыг гүйцэтгэнэ. Үүнд: 1. Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нар хуульд заасан орлогыг сонгуулийн зардлын дансанд төвлөрүүлсэн эсэх? 2. Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нар сонгуулийн зардлын данснаас хуулийн дагуу зарлага гаргасан эсэх?
Аудитын хамарсан хүрээ	Аймаг, сумын ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон намаас нэр дэвшигчдийн хараат бус аудитын дүгнэлт, аудитын дэлгэрэнгүй тайлан, аудит хийгдсэн сонгуулийн зардлын тайлангийн маягтууд, харилцагч банкны дансны хуулга бусад шаардлагатай баримтуудыг хамруулж, аудитыг гүйцэтгэв.
Аудитын арга зүй	Аудитын ажлыг гүйцэтгэхэд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудиторов 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/29 дүгээр тушаалаар баталсан “Аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”-ыг үндэслэн нэр дэвшигчдийн өөрийн хөрөнгө, нам, эвслээс оруулсан хөрөнгө, иргэн, хуулийн этгээдээс авсан хандив түүний зарцуулалтын тайланг шалгаж, аудит хийсэн хуулийн этгээд, нам, эвсэл, нэр дэвшигчдээс лавлагаа, тодруулга авч, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан аудитын

Аудитын шалгуур үзүүлэлт	горимын дагуу нотлох зүйл цуглуулж тайланг, хавсралт маягтуудыг бэлтгэв. Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. • Төрийн аудитын тухай хууль; • Сонгуулийн төв байгууллагын тухай хууль; • Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль; • Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль; • Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудиторов 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/29 дүгээр тушаалаар баталсан “Аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”; • Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудиторов 2024 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан “Баянхонгор аймгийн ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох тухай”; • Бусад холбогдох хууль, дүрэм, журам.
Аудитын багийн бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат удирдаж, аудитын менежер М.Алтантуяа үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Должмаа, аудитор Д.Цэдэвцэвээн, Д.Оюун-Эрдэнэ, А.Адилзаяа нар хамтран гүйцэтгэв. Аудитыг 2025.08.01-ний өдөр эхлүүлж, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторов 2025 оны А/29 дугаар тушаалаар баталгаажуулж, Төрийн аудитын байгууллагын (www.audit.mn) цахим хуудаст 2025.08.28-ны дотор байршуулж, нийтэд мэдээлнэ.

НИЙЦЛИЙН АУДИТЫН ДҮН

БҮЛЭГ 1. АЙМГИЙН ИТХ-ЫН 2025 ОНЫ НӨХӨН СОНГУУЛЬД НЭР ДЭВШИГЧДЭД ИРГЭД, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭЭС МӨНГӨН ХАНДИВ ӨГӨӨГҮЙ БАЙНА.

1.1 Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2¹ дахь заалтын дагуу арилжааны банкинд хандивын данс нээлгэж, дээрх хуулийн 50 дугаар зүйлийн 50.3² дахь заалтын дагуу данс нээсэн мэдээллээ Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны нөхөн сонгуульд Монгол ардын намаас 1, Ардчилсан намаас 1 хүн нэр дэвшсэн байна.

Хүснэгт 1. Нам, эвсэл болон тойрог, нэр дэвшигчийн тоо мэдээлэл

№	Нам, эвслийн нэр	Нам	Эвсэл	Тойргийн тоо	Нэр дэвшигчид
1	МАН	1		1	1
2	АН	1		1	1
3	Эвсэл			0	0
4	Бие даан нэр дэвшигч			0	0
	Нийт	2	0	2	2

Эх сурвалж: Аудитын газрын судалгаа

1.2 Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5³-т заасны дагуу Баянхонгор аймагт үйл ажиллагаа явуулж байгаа Хаан банк 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 5225/01/238 дугаар албан бичгээр, Төрийн банкны салбар 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 40/588 дугаар албан бичгээр Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн байна.

1.3 Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны нөхөн сонгуульд нэр дэвшсэн иргэдийн дансанд Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 52, 53, 54, 55 дугаар зүйлд заасан сонгуулийн хандив ороогүй байна.

Тайлан ирүүлсэн 2 нэр дэвшигчээс 1 нэр дэвшигчийн дансанд орлого зарлагын гүйлгээ гараагүй байна. Нөгөө нэр дэвшигчийн нээсэн сонгуулийн зардлын дансанд хандивын орлого ороогүй ба өөрийн хөрөнгийн эх үүсвэрээс 500.0 мянган төгрөгийг дансанд төвлөрүүлж, сонгуулийн үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

¹ Нам, эвсэл болон нэр дэвшигчийг сонгуульд оролцуулахаар бүртгэх тухай шийдвэр гарснаас хойш энэ хууль болон банкны хууль тогтоомжид нийцүүлэн сонгуулийн зардлын дансыг нээлгэнэ.

² Нам, эвсэл болон нэр дэвшигч нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй.

³ Сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал, эсхүл салбарын эрхлэгч уг дансны бүх гүйлгээний хуулгыг гаргаж, санал авах өдрөөс хойш 30 хоногийн дотор төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1⁴-д заасны дагуу нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээд байхгүй байна.

БҮЛЭГ 2. НЭР ДЭВШИГЧДИЙН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ДАНСНААС ГАРСАН ЗАРДАЛ СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ДЭЭД ХЭМЖЭЭНЭЭС ХЭТРЭЭГҮЙ БАЙНА.

2.1 Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3⁵ дахь заалтыг хэрэгжүүлж аймгийн ИТХ-ын нөхөн сонгуульд нэр дэвшигчид нь сонгуулийн зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн байна.

Хүснэгт 2. Нэр дэвшигчийн ирүүлсэн тайлан

Д/д	Намын нэр	Нэр дэвшигчийн зардлын тайланд				Үүнээс аудиторын хянасан тайлан	Сонгуулийн зардлын тайлангаас	
		Харьяалах нам	Мандатын тоо	Зардлын тайланд			Дансаа бүртгүүлсэн	Дансаа бүртгүүлээгүй
				Дүгнэлт гаргуулсан	Дүгнэлт гаргуулаагүй			
1	Монгол ардын нам	МАН	1	1		1	1	
2	Ардчилсан нам	АН	1	1		1	1	
ДҮН			2	2	0	2	2	0

Эх сурвалж: Аудитын газрын судалгаа

Баянхонгор аймгийн ИТХ-ын Баянлиг сумын 14 дүгээр тойргийн төлөөлөгч сонгох 2025 оны нөхөн сонгуульд оролцсон Монгол ардын намын нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланд “Глобал капитал аудит” ХХК, Ардчилсан намын нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланд “Бяба үрс аудит” ХХК аудит хийж, дүгнэлт гаргасныг намууд хуулийн хугацаанд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр ирүүлсэн байна.

Аймгийн Монгол ардын намын хороо нь дансаа хаалгасан талаарх мэдээллээ төрийн аудитын байгууллагад ирүүлсэн ба Ардчилсан намын хувьд нөхөн сонгуультай холбоотойгоор намаас сонгуулийн зардал гараагүй талаар аудитын хуулийн этгээдтэй хийсэн тайлбар тодруулгад дурдсан байна.

2.2 Тайлан ирүүлсэн 2 нэр дэвшигчийн нэгнийх нь хандивын дансанд орлого зарлагын гүйлгээ гараагүй, нөгөө нэр дэвшигчийн хувьд сонгуулийн хандивын

⁴ Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ.

⁵ Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ.

АУДИТЫН КОД: БНА-2025/79-ШТА-НА Аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх зардлын дансанд гарсан гүйлгээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1⁶ -т заасны дагуу зарлага гаргаж, хуулийн 50 дугаар зүйлийн 50.5⁷ -т заасан зардлын дээд хэмжээнээс хэтрүүлээгүй байна.

Аудитын хуулийн этгээдийн гаргасан аудитын дүгнэлтийг нотлох баримттай тулган шалгахад Монгол Ардын намаас нэр дэвшсэн иргэн сонгуулийн зардлын тайландаа орлого, зарлага “0” дүнтэй “Х” тайлан ирүүлсэн, Ардчилсан намаас нэр дэвшигч иргэн сонгуулийн хандивын дансаар дамжуулан сонгуулийн зардлын тайландаа орлого, зарлага тайлагнаж ирүүлсэн байна. Тус нэр дэвшигчийн нээсэн хандивын дансанд хандивын орлого ороогүй ба өөрийн хөрөнгийн эх үүсвэрээс 500.0 мянган төгрөг оруулж, түүнийгээ сонгуулийн үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Хүснэгт 3. Нэр дэвшигч нарын сонгуулийн зардал (мян.төг)

Зардлын ангилал	Мөнгөн дүн
Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах зардал	0.0
Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар байршуулах зардал	0.0
Намын далбааг гудамж, талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал	0.0
Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал	0.0
Сонгуулийн үйл ажиллагаа /түрээс, урамшуулал, тээвэр, томилолт, сурталчилгаа/	498.0
Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах зардал	0.0
Цахим орчин ашиглах зардал	0.0
Сонин сэтгүүлд материал хэвлүүлэх	0.0
Бусад зардал	2.0
Нийт дүн	500.0

Эх үүсвэр: Аймгийн ИТХ-ын нөхөн сонгуульд оролцсон нэр дэвшигч нарын аудитлагдсан тайлан

2.3 Аймгийн ИТХ-ын нөхөн сонгуульд нэр дэвшигчид нь сонгуулийн зардлын дансаа Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1⁸ дэх заасны дагуу ашиглаж, дансыг хаасан байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Баянлиг сумын 14 дүгээр тойргийн төлөөлөгч сонгох 2025 оны нөхөн сонгуульд оролцсон нэр дэвшигчийн зардлын тайланг аудитын хуулийн этгээдүүд баталгаажуулан, үнэн зөв, иж бүрэн илэрхийлэгдсэн гэж дүгнэлт гарган ирүүлсэн байна.

⁶ Нам, эвсэл болон нэр дэвшигчийг сонгуульд оролцуулахаар бүртгэсэн өдрөөс эхэлж, сонгуулийн зардлын тайлан гаргах өдрийг дуусах хүртэл хугацаанд энэ хуулийн 38.2-т заасан арга хэлбэрээр сонгуулийн сурталчилгаа явуулах зориулалтаар сонгуулийн зардлын данснаас дансанд шилжүүлэх хэлбэрээр зарлага гаргаж болно.

⁷ Сонгуулийн зардлын дансанд хуримтлагдах хөрөнгийн хэмжээнд тусгайлан хязгаар тогтоохгүй боловч тухайн сонгуулийн сурталчилгааны хугацаанд сонгуулийн зардлын данснаас зарцуулах зардлын хэмжээ нь энэ хуульд заасны дагуу тогтоосон сонгуулийн зардлын дээд хэмжээнээс хэтрэхгүй.

⁸ Нам, эвсэл болон нэр дэвшигчийг сонгуульд оролцуулахаар бүртгэсэн өдрөөс эхэлж, сонгуулийн зардлын тайлан гаргах өдрийг дуусах хүртэл хугацаанд энэ хуулийн 38.2-т заасан арга хэлбэрээр сонгуулийн сурталчилгаа явуулах зориулалтаар сонгуулийн зардлын данснаас дансанд шилжүүлэх хэлбэрээр зарлага гаргаж болно.